



МОНГОЛ ДААТГАЛ

МОНГОЛ ДААТГАЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

20 23 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 2314

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг эчнээ санал хураалтаар явуулах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 73 дугаар зүйл, 62 дугаар зүйлийн 62.1.2 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал /цаашид “хурал” гэх/-ыг эчнээ санал хураалтаар явуулахыг зөвшөөрсүгэй.
2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал /цаашид “хурал” гэх/-ыг эчнээ санал хураалтаар дор дурдсан асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:
 - 2.1 Монгол Даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох
 - 2.2 Монгол Даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох
3. Эчнээ санал хураалтыг 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс 2023 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 12:00 цаг хүртэл явуулсугай.
4. Хурлын мэдэгдлийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Биржид тус тус хүргүүлсүгэй.
5. Хурлын мэдэгдлийг Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудас, өдөр тутмын хоёроос доошгүй сонин болон бусад мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2023 оны 06 дугаар сарын 19-ний өдөр олон хийтэд мэдээлж, уг мэдэгдлийг 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдөр анх зарласан хэлбэрээр дахин нийтэд мэдээлсүгэй.
6. Хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрөөр тогтоосугай.



Буухиа даатгал: +976 7010-1990
Даатгалын лавлах: +976 1800-1990



www.mongoldaatgal.mn
insurance@mongoldaatgal.mn

7. Хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, танилцуулга, саналын хуудас зэрэг бусад холбоотой баримт бичгийг 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдөр үнэт цаасны компаниудад хүргүүлсүгэй.
8. Хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Громов С.Б.-г томилсугай.
9. Хурал зохион байгуулах комиссын даргаар Т.Цацралыг томилсугай.
10. Хурлаар хэлэлцэх асуудлыг энэхүү шийдвэрийн Хавсралт №01-ээр, саналын хуудасны загварыг Хавсралт №02-оор, танилцах бичиг баримтын жагсаалтыг Хавсралт №03-аар, хурлын зарыг Хавсралт №04-өөр, тооллогын комиссыг Хавсралт №05-аар тус тус баталсугай.
11. Хувьцаа эзэмшигчдийг хурлын материалтай танилцах нөхцөл, боломжийг бүрдүүлж ажиллахыг Хурал зохион байгуулах комисс /Т.Цацрал/-д даалгасугай.
12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хугацаанд Монголын Хөрөнгийн Бирж, Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлэхийг хурал зохион байгуулах комисс /Т.Цацрал/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



ГРОМОВ С.Б.

“Монгол Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн
23/14 тоот тогтоолын Хавсралт №01



**МОНГОЛ ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН
ЭЧНЭЭ САНАЛ ХУРААЛТААР ХЭЛЭЛЦЭЖ ШИЙДВЭРЛЭХ АСУУДЛЫН ЖАГСААЛТ**

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

“Монгол Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн
23/14 тоот тогтоолын Хаесралт №02



**“МОНГОЛ ДААТГАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ЭЧНЭЭ САНАЛ ХУРААЛТЫН ХУУДАС**

1. Хувьцаа эзэмшигчийн овог нэр: _____
2. Регистрийн дугаар: _____
3. Эзэмшиж буй хувьцааны төрөл: _____
4. Эзэмшиж буй хувьцааны тоо: _____
5. Хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны дансны дугаар: _____
6. Үйлчилсэн ҮЦК-ийн нэр: _____
7. Үйлчилсэн ҮЦК-ийн ажилтны овог, нэр: _____

№	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Нэр дэвшигчид өгөх саналын тоо
1		
2		
3		
4		
5		
6		

№	ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Нэр дэвшигчид өгөх саналын тоо
1		
2		
3		

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг _____/...../

Санал авах хуудсыг үйлдсэн 2023 онысарын-ны өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх:

Тооллогын комиссын дарга _____/...../

Хүчингүйд тооцсон бол шалтгаан:

Санал авах хуудсыг ашиглах санамж

1. Засварласан, балласан, залруулгатай санал авах хуудсыг нь хүчингүйд тооцогдоно.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгохдоо санал өгөх кумулятив аргыг ашиглана. Энэ аргаар саналаа өгөхдөө эзэмшиж буй хувьцааныхаа тоог 6-аар үржүүлж гарсан тоог ердийн гишүүнд нэр дэвшиж буй 6 хүнд дурын харьцаагаар хувааж өгнө. Харин хувьцааныхаа тоог 3-аар үржүүлж гарсан саналын тоог хараат бус гишүүнд нэр дэвшиж буй 3 хүнд дурын харьцаагаар хувааж саналаа өгнө. Тухайлбал, таны эзэмшиж буй хувьцааны тоо 100 гэвэл 600 саналыг ердийн гишүүнд нэр дэвшиж буй 6 хүнээс нэг хүнд бүгдийг нь өгч болно, эсвэл нэгэнд нь 500 саналаа 2 дахад нь 100 саналаа гэх мэтээр ямар ч харьцаагаар хувааж өгч болно. 300 саналаа хараат бус гишүүнд нэр дэвшиж буй нэг хүнд бүгдийг нь эсвэл 3 хүнд адилхан 100 санал өгөх мэтээр хувааж өгч болно. Гэхдээ хараат бус гишүүнд нийт саналынхаа $\frac{1}{3}$ -ыг ердийн гишүүнд нийт саналынхаа $\frac{2}{3}$ -ыг өгсөн байх ёстой. Ингээгүй бол саналын хуудас хүчингүйд тооцогдоно.
3. Хувьцаа эзэмшигч өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол зуучлагч брокерийн пүүс дээр очиж хурлын материалтай танилцаад санал авах хуудсаар саналаа өгнө. Энэ тохиолдолд саналын хуудсыг хүлээн авсан брокер гарын үсэг зурж, тэмдэг дарсан байна.
4. Хэрэв саналаа өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүний овог нэр, хаягийг дор бичих бөгөөд өөрийн санал авах хуудас, иргэний үнэмлэх, хувьцаа эзэмшиж буй баталгаа болгон үнэт цаасны хадгаламжийн дансны хуулгыг хамт өгч явуулна.

Таны төлөөлөх хүний овог: нэр:.....

Оршин суугаа хаяг:

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын талаар 94001934 утсаар лавлаж болно.

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон бол шалтгаан:.....

*“Монгол Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн
23/14 тоот тогтоолын Хавсралт №03*



**“МОНГОЛ ДААТГАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРАЛТАЙ
ХОЛБОГДУУЛАН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД ТАНИЛЦУУЛАХ БАРИМТ БИЧГИЙН
ЖАГСААЛТ**

1. Монгол Даатгал ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг эчнээ санал хураалтаар явуулах тухай 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 23/14 тоот тогтоол
2. Монгол даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшиж буй гишүүдийн танилцуулга
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар санал өгөх Саналын хуудасны загвар
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас гарах тогтоолын төсөл



*"Монгол Даатгал" ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн
23/14 тоот тогтоолын Хавсралт №04*

"МОНГОЛ ДААТГАЛ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫГ ЭЧНЭЭ САНАЛ ХУРААЛТААР ЯВУУЛАХ ЗАР

Монгол даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 23/14 тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг эчнээ санал хураалтаар явуулах тухай зарлаж байна.

Компанийн оноосон нэр: "Монгол даатгал" ХК

Хаяг: Монгол даатгалын төв байр, Үндсэн хуулийн гудамж, 5-р хороо, Улаанбаатар - 14253
Монгол улс

/what3words : ///сувгууд.хором.зүлгэж/

Саналын хуудас хүлээж авах эцсийн өдөр: 2023 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 12:00 цаг хүртэл

Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр: 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдөр

Санал хураалтаар шийдвэрлүүлэх асуудлууд:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Хувьцаа эзэмшигчдийн танилцах баримт бичгийн жагсаалт:

1. Монгол Даатгал ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг эчнээ санал хураалтаар явуулах тухай 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 23/14 тоот тогтоол
2. Монгол даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшиж буй гишүүдийн танилцуулга
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар санал өгөх Саналын хуудасны загвар
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас гарах тогтоолын төсөл

Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбоотой баримт бичигтэй танилцах журам, газар, ажиллах цаг:

- Хувьцаа эзэмшигч Та 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрөөс 2023 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 12:00 цаг хүртэл өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанидаа

хандах, компанийн Facebook хуудсаар Mongol Daatgal JSC эсвэл компанийн байранд ирж, хурал зохион байгуулах комиссын дарга Т.Цацралд мэдэгдэн хурлын баримт бичигтэй танилцаж болно.

- Саналын хуудсаа бөглөж ирүүлэх зааврыг цахим хуудаст тавигдсан мэдээллээс авна уу.
- Хурал зохион байгуулах комисс нь Даваа-Баасан гарагт 09.00 -17.00 цагийн хооронд ажиллана.

Хурал зохион байгуулах комиссын даргын мэдээлэл:

Дарга:

Овог нэр: Түдэвийн Цацрал

Цахим шуудангийн хаяг: Tsatsral.T@mongoldaatgal.mn

Утас: 9400-1934

ЭЧНЭЭ САНАЛ ХУРААЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС